

# ОРОЛЦОГЧДОД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

## Нийгэмшүүлэх циркийн суурь сургалт – Нэгдүгээр ХЭСЭГ

Энэхүү гоёмсог гарын авлагын эзний нэр бол:

Улаанбаатар, Монгол  
2012 оны 3 дугаар сарын 26-30

Сургагч багш нар:  
**Кагинн Лавуа**  
**Исабэлл Массе**

CIRQUE DU SOLEIL™



*Найруулан зохион байгуулсан:* Дэвид Симард, Клаудиа Мариса Рибэйро  
*Агуулгыг баталсан:* Эммануэл Бошуд, Лино де Жиованни, Хелен Брунет  
*Хамтран боловсруулсан:* Мишел Лафортун, Элиса Монтарули, Нормандэ Хэбэрт, Лино де Жиованни, Стефан Батине, Хелен Брунет, Анни Бушард, Лорензо Занетти, Дирче Морелли, Эммануэл Бошуд, Дэвид Симард, Андреа Семинаро, Жан-Рок Ашард, Даниэл Туркот, Жоселин Линдсей, Кристиан Баретте, Эдит Годет, Денис Лимей, Ричард Прегент

Дизайн:

Зургийг: Пиер Демарай  
График дизайныг: Мария Маселла  
Хянан тохиолдуулсан: Доминик Пикард  
Гэрэл зургийг: Габриэл Бенжамин Перез Роблз (“Табо” хочтой)

Зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр өөрчлөн боловсруулахыг хатуу хориглоно. Үүнийг зөрчсөн тохиолдолд иргэний болон эрүүгийн хэрэг үйлдсэнд тооцогдоно.

**Зохиогчийн эрхийг баталгаажуулсан болно.**

**Канад улсад бүтээв.**

CIRQUE DU SOLEIL



© 2012 Нарны цирк  
[cirquedusoleil.com](http://cirquedusoleil.com)

Нарны цирк буюу Cirque du Soleil нь Нарны циркийн эзэмших тэмдэгт бөгөөд лицензтэй ашиглагддаг болно.

# НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН СУУРЬ СУРГАЛТ

“Нарны цирк” -ээс гаргасан Нийгэмшүүлэх циркийн суурь сургалтын хөтөлбөрийн зорилго нь олон нийтийн буюу нийгмийн ажилтан, циркийн дасгалжуулагч багш нарыг эрсдэлд буй хүмүүст Нийгэмшүүлэх циркийн сургалт зохион байгуулахад бэлтгэх явдал юм. Энэхүү сургалт нь Нийгэмшүүлэх циркийг хэрэгжүүлэх ерөнхий шаардлага, ач холбогдолыг бүрэн дүүрэн ойлгуулахад чиглэнэ. Мөн сургагч багш нарт төрөл бүрийн соёл, нийгмийн орчинд тохируулан хамтрагчидтайгаа нэгдэн ажиллах ур чадварыг хөгжүүлэх зорилготой болно.

## Сургалтын ерөнхий зорилт:

- Хувийн болон мэргэжлийн ёс суртахууныг өндөр түвшинд хөгжүүлэх;
- Оролцоонд тулгуурласан, шинэлэг заах арга барилын үндсэн ойлголтуудыг таниулах;
- Олон нийтэд суурилсан сургалтын орчныг хөгжүүлэх;
- Урлагийг хувь хүний хөгжилд ашиглах зэмсэг болгон ашиглаж сургах.

## ГАРЧИГ:

Нийгэмшүүлэх цирк	5
Багийн ажил	9
Олон нийтийн буюу нийгмийн ажилтан, дасгалжуулагч багшийн үүрэг	13
Аюулгүй байдал	21
Ёс суртахуун	27
Заах арга барил	35
Хичээл төлөвлөлт	43
Бүтээлч ур чадвар	49
Хавсралтууд	
Загвар: Нийгэмшүүлэх циркийн хичээлийн төлөвлөлт	57
Загвар: Нийгэмшүүлэх циркийн сургалтын төлөвлөлт	59
Загвар тоглоомууд	61
Тэмдэглэл	65





# НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Нийгэмшүүлэх циркийн тухай зохих ойлголттой
2. Нийгэмшүүлэх циркийн зарчим болон зорилтуудыг таниж мэддэг
3. Нийгэмшүүлэх цирк нь нийгмийг өөрчлөх нэг арга болохыг ойлгодог

*Бид 2009 онд Бэй-Сэинт-Поул дахь Дэлхийн Циркийн жилийн чуулганд оролцож байлаа. Шөнийн нэг цагийн үед би оролцогч залуустай тэрхүү хамтдаа өнгөрөөсөн гайхалтай сайхан өдрийн тухай ярилцаж суутал нэг нь тэр өдөр өөрийн бичсэн шүлгийг уншихыг хүссэн юм.*

*Тэр шүлэгт “Цирк надад гүнээ нөлөөлж, амьдралыг минь өөрчиллөө. Цирк миний чадал чадварыг нээж, шинэ арга барил эзэмшихэд тусаллаа. Би бүх насаараа циркээр ажиллаж, циркээр амьсгалахыг хүсч байна. Энэ бүхэн надад шинийг мөрөөдөх хүсэл эрмэлзэл төрүүлж байна” гэсэн байв. Надад өөр олон оронд хүүхэд залуусын иймэрхүү санал сэтгэгдлийг сонсож, тэднийг давуу талаа хэрхэн нээн таниж, урам зориг нь бадарч буйг олж харах таатай боломж олдож байсан. Би эдгээр сэтгэгдлийг сонсох бүртээ энэхүү туршлага нь хувь хүний болон нийгмийг өөрчлөх хүчтэй хөшүүрэг болж болохыг улам гүнзгий ойлгож мэдэрдэг. Дэлхий даяар хүүхэд залуучууд тайзан дээр хөл тавьж ирээдүйгээ өөрөө бүтээх сонголт хийж байна. Тийм хүүхэд залуучуудын хувьд Нийгэмшүүлэх цирк нь агуу том гараа болж байна.*

Лино де Жиованни, Нийгэмшүүлэх циркийн Сургалтын менежер  
Нарны цирк, Монтреал хот





## НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ЗАРЧМУУД

1. Аюулгүй, бас хөгжилтэй орчин

---

---

---



2. Олон нийттэй холбогдох хэлхээ холбоо

---

---

---



3. Өөрийгөө илэрхийлэх боломж ба бүтээлч байдал

---

---

---



4. Нийгмийн ажил, цирк хоорондын хамтын ажиллагаа

---

---

---



5. Цагийн эрхэнд үл бүдгэрэх тогтвортой чанар

---

---

---



6. Оролцогч төвтэй арга барил

---

---

---



7. Түншлэл, хамтын ажиллагаа

---

---

---





Нийгэмшүүлэх цирк нь циркийн урлагаар дамжуулан нийгэмд өөрчлөлт хийх шинэлэг арга юм.

Нийгэмшүүлэх цирк нь олон нийтийн буюу нийгмийн ажилтнууд, циркийн жүжигчдийн чадварыг өндөр түвшинд ашигладаг.

Нийгэмшүүлэх цирк нь хүүхэд залуучууд болон олон нийтийн хүрээнд өөрчлөлт гаргах асар том бололцоо юм.

Нийгэмшүүлэх цирк нь хурдацтайгаар түгэн дэлгэрч буй дэлхийн хөдөлгөөн юм.



# БАГИЙН АЖИЛ

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Хэрхэн багаар ажиллахыг ойлгосон
2. Багаар амжилттай ажиллахад чухал элементүүдийг мэддэг
3. Тэдний зан үйл тухайн багийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг үнэлж дүгнэдэг

*Бид хамтран ажиллагчаа өөрийн нэгэн үргэлжлэл гэж харж, хүлээн зөвшөөрөхгүйгээр тэдэнтэй хамтдаа өсөн дэвжиж чадахгүй... Сургагч багшийн хувьд би гадаад, дотоодын олон өөр сургагч багштай хамтран ажиллаж, тэднээс суралцах аятай боломж олдож байсан. Бид өөрсдийн хийсэн ажиглалт, санал бодлоо хоорондоо солилцсоноор төсөөлөл, үзэл бодлоо өөрчлөн хувиргаж, энэ нь биднийг улам өсөн дэвжихэд нөлөөлдөг. Бразилд болсон нэгэн сургалтын үеэр бид нэгэн Бразил сургагч багштай ажиллах ёстой байлаа. Бид тэнд очих үедээ долоо хоногийн төлөвлөгөөгөө аль хэдийн гаргачихсан байсан. Харин сургагч багштай уулзтал тэр ч мөн тухайн нөхцөл байдалдаа тохируулан төлөвлөгөө гаргасан байсныг олж мэдлээ. Энэ нь биднийг жаахан хүнд байдалд оруулав. Тэгээд бид уулзаж удаан гэгч ярилцан дараах өдрийн төлөвлөгөөгөө гаргасан юм. Хамтдаа ямар нэг зүйл хийхийн тулд бид цаг гаргаж, өөрсдийн давуу тал, нөөц боломжийг нэтгэсэн сургалт төлөвлөх хэрэгтэй болохыг ойлгосон юм. Бид тэнд сургалт явуулахаар очсон ч багаар ажилласан туршлага маань өөрөө бас бидэнд сургалт болсон юм.*



Лино де Жиованни, Нийгэмшүүлэх циркийн Сургалтын менежер  
Нарны цирк, Монтреал хот



## БАГАА ХҮЧТЭЙ, ЗӨВ ЗОХИСТОЙ БАЙЛГАХ ДОЛООН ЗӨВЛӨМЖ

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр нь багаар ажиллаж хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд дараах долоон хүчин зүйлийг санаж байх ёстой.

### 1. Тоог хязгаарла

---

---

---

### 2. Хамаарах мэдрэмжийг бий болго

---

---

---

### 3. Хувь хүний хүчин чармайлтыг дэмж

---

---

---

### 4. Эв нэгдлийг хадгал

---

---

---

### 5. Нэгдмэл зорилтод чиглэ

---

---

---

### 6. Эцэс хязгаарыг хүлээн зөвшөөр

---

---

---

### 7. Бүтцийг бий болго

---

---

---



Хүчтэй баг нь төлөвлөсөн ажилдаа ч, бүлэгтээ ч анхаардаг.

Нэгдмэл зорилт тодорхойлж, түүнийхээ төлөө явах нь багийн бүх гишүүдийн авъяас чадвар, хүчин чармайлтыг гаргаж чаддаг.

Багийн ажил нь зохион байгуулалт, дасан зохицох асар их чадавхийг шаарддаг.



# НИЙГМИЙН АЖИЛТАН БОЛОН ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН ҮҮРЭГ

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

- 1. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтны эзэмшвэл зохих чадвар, хандлага, мэдлэгийг нарийн тодорхойлж чаддаг.**
- 2. Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр үүргийнхээ хувьд хэрхэн нэг нэгнээ харилцан нөхдөгийг ойлгосон**
- 3. Эдгээр үүрэг хариуцлагын хязгаар, боломжит хүрээ, мөн хослон заах арга барилын давуу талыг таньж мэдсэн**

*Циркийн дасгалжуулагч багш нар нь арга зүй, техникийн талын мэдлэгтэй байдаг. Гэвч зарим тохиолдолд тэд үүссэн нөхцөл байдлыг зохицуулахад хангалттай бэлтгэгдээгүй байдаг тул биднийг оролцохыг хүсдэг. Жишээ нь нэг удаа залуучуудын нэг төвөөс ирсэн хүү сургалтанд оролцож байсан юм. Хүү яагаад ч юм өөрт нь туслаж байсан олон нийтийн ажилтанд уурлаж, хүчтэй бухимдаж эхлэсэн. Тэрээр дасгалжуулагчийн хэлж буй үгийг сонсохоо болж, ухаан алдатлаа уурлаж байсан. Түүнийг ийнхүү хямарч байхад дасгалжуулагч яаж ч хичээгээд өөрийгөө ойлгуулж чадахгүй байлаа. Тэрээр хүүгийн байдлыг улам сэдрээж, хяналтыг гараасаа алдсан. Хүү тэр үед байшинг нураах нь уу гэмээр аашилж байлаа. Ингээд бид дасгалжуулагчийг түр холдуулж, хүүгийн уур гартал хүлээхийг хүслээ. Хүүг бага зэрэг тайвшрахад нь би тэрхүү асуудалд оролцоогүй байсан хүний хувьд түүнийг тайвшруулахаар дөхөж очсон юм.*

Силвэин Демерс, Нийгэмшүүлэх циркийн зохицуулагч  
Квебек дахь Жак-Картиегийн Олон нийтийн төв





## ОЛОН НИЙТИЙН БУЮУ НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ

Олон нийтийн буюу нийгмийн ажилтны ерөнхий үүрэг нь нийгэмшүүлэх циркийн төсөл болон оролцогчид хооронд холбох явдал юм. Орон нутгийн байгууллагаас томилогдсон энэхүү мэргэжилтэн нь оролцогчдын амьжиргааны талаар нарийн ойлголттой байх нь их ба зарим үед амьдралынх нь тодорхой хэсгүүдэд хамт байж хүндрэл бэрхшээлээ даван туулахад тусалсан туршлагатай байдаг.

### Олон нийтийн буюу нийгмийн ажилтны тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч орон нутаг, байгууллагаас томилогдсон нийгмийн ажлын мэргэжилтэн юм. Түүний гол үүрэг нь олон нийттэй ажиллан циркийн хичээлийг амьдралын сургамж болгоход туслах замаар тэдний хөгжлийг дэмжих явдал юм.

Нийгмийн ажилтан нь оролцогчдын амьдралыг тийнхүү мэддэг байснаараа тэдний сонирхолыг нийгэмшүүлэх циркийн төсөлд чиглүүлж, барих боломжтой байдаг. Тэрээр мөн оролцогчидтой итгэлцлийн нягт холбоог бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулж чаддаг.

Нийгмийн ажилтны эхний үүрэг нь циркийн хичээлийн бэлтгэл ажлыг хангах явдал юм. Үүнд шинэ оролцогчид элсүүлэх, байр олох, сургалтын төлөвлөгөөг гаргах зэрэг орно. Сургалтын явцад түүний гол үүрэг нь оролцогчидтой итгэлцлийг бий болгох явдал бөгөөд энэ нь нийгэмшүүлэх циркийн арга барилыг үр дүнд хүргэдэг нэгэн суурь нөхцөл юм. Тэрхүү бий болгосон харилцааны чанар нь цаашдын ахиц дэвшлийн үндэс болж байдаг. Нийгмийн ажилтан, оролцогчид хоорондын холбоо хүчтэй байгаа нөхцөлд л циркийн хичээл нь амьдралд хэрэгтэй сургамж болж чадна.

**Олон нийтийн буюу нийгмийн ажилтны үүрэг хариуцлагын талаар нэмэлт мэдээллийг “Циркийн хичээлийг амьдралын хичээл болгох нь- Олон нийтийн ажилтанд зориулсан зөвлөмж” гарын авлагын 34-39 дүгээр хуудсаас үзнэ үү.**<sup>1</sup>

Notes

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---



<sup>1</sup> Ишлэлийг Мишел Лафортун, Анни Бошард нарын зохиосон “Циркийн хичээлийг амьдралын хичээл болгох нь- Олон нийтийн ажилтанд зориулсан зөвлөмж”, Нийгэмшүүлэх циркийн сургалт (Монтреал:Нарны цирк, 2010), хууд. 33-39.

## НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ҮҮРЭГ<sup>2</sup>

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш нь сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болох циркийн арга техникийг заахын зэрэгцээ хүүхэд залуучуудын хувьд үлгэр жишээ болох замаар нийт хөгжилд нь туслах чухал үүрэгтэй.

### Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчийн тодорхойлолт

Нийгэмшүүлэх циркийн сургалтанд оролцогчдод циркийн урлагаас заах үүрэгтэй циркийн жүжигчин юм.

Циркийн урлагийг заах нь эрсдэлд буй хүүхэд өсвөр үеийнхэнтэй итгэлцлийн харилцаа тогтоож, тэдний цаашдын хөгжилд хэрэгтэй нөөц боломжийг олгох нэгэн шалтаг юм.

Дасгалжуулагч багш нь эмзэг бүлгийн хүүхэд өсвөр үеийнхэн, тэдний амьдралын орчин дахь үй олон хүчин зүйлийг ойлгохын тулд нийгмийн талаар сайн ойлголттой, заах арга барил сайтай, нээлттэй чөлөөт сэтгэлгээтэй байх шаардлагатай. Дасгалжуулагч нь мөн оролцогчдын эзэмшиж чадах чадварын талаар зөв зохистой хүлээлттэй байж, үр дүнд төвлөрөхөөсөө илүүтэй хүчин зүтгэлийг нь үнэлэхэд ач холбогдол өгөх хэрэгтэй.

Дасгалжуулагч багшийн үүрэг хариуцлага нь ажлын мандатаар нь тодорхойлогдоно. Мандатыг нь тухайн хөтөлбөр хэр гүнзгий шатанд хүрсэн, циркийн хөтөлбөрт оролцогч хүүхэд өсвөр үеийн хөгжил, нөхцөл ямар байгаагаас шалтгаалан тодорхойлно.

### ДАСГАЛЖУУЛАГЧИЙН МАНДАТЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Ажил олгогч байгууллагаас олгох мандат нь нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багшийн үйл ажиллагааны хүрээ, хариуцлагыг тодорхойлж байдаг. Энэ нь дасгалжуулагч багш болон ажил олгогчийн аль алинд төдийгүй тухайн талбарт ажиллаж буй орон нутгийн болон бусад ажилтнуудад (байгууллагын зохицуулагч, туслах дасгалжуулагч, олон нийтийн буюу нийгмийн ажилтан гэх мэт) тодорхой байх ёстой. Мандат тодорхой, хүлээлт бодитой байхын хэрээр зорилтууддаа хүрэхэд хялбар байдаг.

Дасгалжуулагчийн мандат нь доорхи хүчин зүйлсээс хамаарна:

- Дасгалжуулагчийн статус (зохицуулагч, туслах, дадлагажигч гэх мэт)
- Хувь хүний туршлага болон чадвар
- Тухайн үед хөтөлбөр нь хэр гүнзгий түвшинд байгаа
- Ажлын мандатын хугацаа
- Олон нийт болон түнш байгууллагуудын хэрэгцээ, хүлээлт

### ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН ЗОРИЛТУУД

Ажил үүргийн дагуу нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш нь дараах зүйлсийг хийх чадвартай байна:

- Нийгэм, эдийн засаг, соёлын нөхцөл байдалд хийгээд оролцогчдын чадварт нийцүүлэх
- Ажил явагдаж буй орон нутгийн соёл, хэв маяг, онцлог заншилыг анхаарах
- Байгаа нөөц боломжийг түргэн олж илрүүлэн, сургалт явуулах үйл явцыг амарчлах.
- Хамтрагч байгууллагын алсын хараа болон дүрэм журмыг хүндэтгэх.
- Орон нутаг дахь бусад хүмүүсийг (гэр бүл, найз нөхөд, хамтрагч байгууллагын гишүүд) оролцох, хүүхэд залуучуудын оролцоог дэмжихэд нөлөөлөн урамшуулах

<sup>2</sup> Энэ эхийн ишлэлийг Мичел Лафортунй “Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчийн үүрэг” ном болон С.Дагенайс, С. Мерсиер, Ж. Ривард нарын “Нийгэмшүүлэх циркийн хөтөлбөрийн дасгалжуулагч, хамтрагчидад зориулсан гарын авлагын Хоёрдугаар хэвлэл(Монтреал: Нарны цирк, Нийгмийн хэрэг, олон улсын харилцааны салбар, 2001), Баримтат хуудас 8.”-аас авав.

## ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багшийн хариуцлага нь түүнд олгосон мандатаас хамаарах бөгөөд хамтрагч орон нутагтай хамтран хариуцах ёстой. Хүлээх хариуцлагууд нь:

- Циркийн сургалтыг зохион байгуулах, төлөвлөх
- Циркийн сургалтыг оролцогчдын ур чадвар, хэрэгцээ шаардлагад нийцэхээр зохион байгуулах: циркийн урлагийг танилцуулах, арга техникийг сайжруулах, урлагийн бусад аргуудыг танилцуулах (жүжиглэлт, дүр гэх мэт), олон нийтэд зориулсан тоглолт үзүүлбэрт бэлтгэх
- Сургалтад зориулан бие махбод, сэтгэл санааны хувьд тохиромжтой аюулгүй орчныг бий болгох
- Эд ахуй болон арын ажлын зохион байгуулалтыг зохицуулах
- Сургалтын бэлтгэлээс эхлэн сургалт явуулах бүх шатанд үнэлж дүгнэн холбогдох бүлэгт танилцуулах

## ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН ҮҮРЭГ:

Оролцогчдын өмнө дасгалжуулагч багшийн хүлээх үүрэг нь:

- Оролцогчдын бүх талын хөгжлийг бодолцсон арга барилын хүрээнд циркийн арга техникийг оролцогчдын чадвар туршлагад нийцсэн байдлаар бэлтгэж заах.
- Оролцогчдыг сонсон, тэдний хэрэгцээ шаардлага, хөгжлийн үе шат, хязгаарыг анхаарах.
- Оролцогчдыг сургалтаар дамжуулан чадавхижуулж, сургалтын явцад оролцогчдыг сэдэлжүүлж, идэвхижүүлэх маш олон төрлийн арга барилыг ашиглах.

Нийгмийн ажилтнуудын өмнө дасгалжуулагч багшийн хүлээх үүрэг нь:

- Итгэлцэл бүхий харилцааг бий болгож, хослон заах аргын хүрээнд нэг нэгнээ харилцан дэмжсэн, эв нийцэлтэй баг болон ажиллах

Хамтрагч байгууллагын захирлуудын өмнө дасгалжуулагч багшийн хүлээх ёстой үүрэг нь:

- Аажимдаа тухайн орон нутагт, олон нийтэд тус хөтөлбөрийн удирдлагыг хүлээлгэн өгөхөд бэлтгэх.

Эцэст нь дасгалжуулагч багш олон нийтийн өмнө дараах үүрэг хүлээнэ:

- Тэднийг циркийн үйл ажиллагаа, олон нийтэд зориулсан тоглолтод оролцуулах зэргээр эрсдэлд буй хүүхэд залуучуудын талаарх олон нийтийн хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх юм.

## ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН БАЙР СУУРЬ БА СЭДЭЛ

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш нь олгогдсон мандат болон хувь хүний амбиц хоёроо бодож хооронд нь буулт хийх ёстой болдог. Ингэснээр дасгалжуулагч нь хийх ажил, төсөлд хамтран оролцогч нарынхаа хүлээлт дунд зөв зохицуулалт хийж, тэнцвэртэй байдалд байж чаддаг.

Дасгалжуулагч багшийн сэдэл нь сайн дурын ажилтнуудтай холбоотой яригддаг дараах дөрвөн үнэт зүйлээр мөн тодорхойлогдож болно. Үүнийг олон улсын хөгжлийн салбарт ажилладаг ТББ (Төрийн бус байгууллага) –ууд дараах байдлаар тодорхойлдог:

- Мэргэжлийн сорилт
- Нийгмийн ажил
- Соёлын сорилт
- Хувийн туршлага





# ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ БОЛОН ОЛОН НИЙТИЙН АЖИЛТНЫ ТАНИЛЦУУЛГА

## ЦИРКИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ

ТОЛГОЙ (мэдлэг)

ГАР (чадвар)

МӨР (хариуцлага)

ЗҮРХ (хандлага)

ХӨЛ (туршлага)

ГАДАГШ (хязгаар)

## НИЙГМИЙН АЖИЛТАН

ТОЛГОЙ (мэдлэг)

ГАР (чадвар)

МӨР (хариуцлага)

ЗҮРХ (хандлага)

ХӨЛ (туршлага)

ГАДАГШ (хязгаар)







Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш болон нийгмийн ажилтны аль аль нь оролцогчид, сургагч багш нарын багийн бусад гишүүд, хамтрагч байгууллага болон олон нийтийн хэрэгцээ шаардлага болон тухайн нөхцөлдөө ч маш сайн дасан зохицдог байх ёстой.

Насанд хүрэгчдийн хувьд дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр нь оролцогчдодоо үлгэр жишээ болдог.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр нь нийгмийн өөрчлөлтийг өдөөгч, дэмжигч болон түлхэц болж чаддаг байх ёстой.

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр нь оролцогчидтой харилцахдаа тогтвортой, найдвартай байдлыг харуулах нь зайлшгүй чухал.

# АЮУЛГҮЙ БАЙДАЛ

## ЗОРИЛТ:

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

- 1. Бие махбод, сэтгэл санааны хувьд аюулгүй байдлыг хангах нь сургалтын амжилтын үндэс болдог гэдгийг ойлгосон**
- 2. Аюулгүй байдалд тогтмол анхаарч чаддаг болсон.**
- 3. Циркийн сургалтанд тохирсон аюулгүй орчинг бий болгох арга замыг сурсан**

*Манай хөтөлбөрийн нэг хэсэг нь тоног төхөөрөмжөө гадагш авч гарахыг шаарддаг. Нэг өдөр бид цэцэрлэгт хүрээлэнд очтол нэг хүү модон хөл хэрэглэе гэж шаардав. Гэвч тэрээр арав гаруй шил шар айраг уучихсан, согтуу байсан тул бид “болохгүйээ, чи жонглёр тоглож болох ч хөл хэрэглэж болохгүй” гэж хэлж зогсоосон юм. Маргааш өдөр нь тэр хүү модон хөлөн дээр явж үзэхийн тулд архи уулгүйгээр биднийг хүлээж байлаа. Тэр өдрөөс хойш хүү биднийг гарч ирэх бүрт архи уулгүй байж байдаг байсан юм. Энэ нь түүнд архины хэрэглээгээ зохицуулах нэг арга болж билээ.*

Кагинн Лавуа, Нийгэмшүүлэх циркийн Сургагч багш  
Нийгэмшүүлэх цирк, Монтреал





## ОРОЛЦОГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХЯНАЛТ

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан хоёр дүрмээ тогтоохдоо доорх дөрвөн аюулгүйн зарчмыг мөрдөх шаардлагатай:

1. Ослоос урьдчилан сэргийлэх
2. Зохих арга хэмжээг авах чадварыг хөгжүүлэх
3. Оролцогчдод аюулгүй байдлын боловсрол олгох
4. Оролцогчдын сэтгэл санааны аюулгүй тайван байдлыг хангах

### 1. ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Сайн урьдчилан сэргийлэлт нь дасгалжуулагч багшийн ажлыг хялбарчилж өгдөг. Тиймээс сургалтын баг нь бүх тоног төхөөрөмж, хэрэгслийг тогтмол, системтэйгээр шалгаж, ажиллах нөхцөл аюулгүй байгаа эсэхийг баталгаажуулах ёстой. Мөн сургалтын баг нь болзошгүй эрсдэлийн эх үүсвэрийг тодорхойлж, тэдгээр эрсдэлийг үгүй болгох, эсвэл зайлсхийх бүхий л арга хэмжээг авах ёстой.

### 2. ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ

Аюулгүй байдлын талаар сайн мэдээлэл авах нь дасгалжуулагч багш нарт аюултай нөхцөл байдал үүсэхэд хэрхэн хурдан, аюулгүй болгох аргыг зааж өгдөггүй. Дасгалжуулагч багш нар нь онцгой байдал үүсэхэд хэрхэн зөв зохистой арга хэмжээ авахыг сурахад бэлтгэл сургуулилт, цагийн байдал, дадлага хэрэгтэй.

Сургалтын багийн бүх гишүүд нь анхны тусламжийн сургалтанд бүрэн хамрагдсан байвал сайн. Тэд онцгой байдалд зохих арга хэмжээг авах, эсвэл ийм үед удирдлагыг гартаа авах хүнд хэрхэн туслах талаар мэддэг байх ёстой.

### 3. ОРОЛЦОГЧДОД АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ ОЛГОХ

Аюулгүй байдлын асуудал дасгалжуулагч багшийн хариуцах асуудал ч оролцогчдод мөн анхаарах асуудал байх ёстой. Тиймээс дасгалжуулагч багш нь эхнээсээ л аюулгүй байдлын арга хэмжээг зааж өгөх хэрэгтэй.

Дасгалжуулагч багш нь оролцогчдод циркийн арга техникээр хичээллэхэд үүсч болзошгүй аюул эрсдэлийг ойлгоход нь туслаж, аюулгүй хэрхэн биеэ авч явахыг заах хэрэгтэй. Аюулгүй байдлын талаар заах нь оролцогчдыг өөрсдийн бие махбодын хязгаарыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, болон бусдыг анхаардаг байхад тустай. Аажмаар, сургалтад оролцох тусам тэд өөрсдийн аюулгүй байдалдаа хариуцлагатай хандах нь нэмэгдэж, сургалтын явцад хэрхэн бусдад туслах болон дэмжих талаар суралцдаг.





# НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН СУРГАЛТЫН ҮЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХУУДАС

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГААЖИЛТЫН ХҮЧИН ЗҮЙЛС	МӨРДСӨН ЭСХЭТ ИЙМ/ҮГҮЙ	ҮГҮЙ БОЛ ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?	АВСАН АРГА ХЭМЖЭЭ	
			АРГА ХЭМЖЭЭ	ОГНОО
<b>■ БАЙР</b>				
Сургалтын бүс нь сайтар зааглагдсан, нуранги, хоггүй				
Гэрэл, агааржуулагч тохиромжтой				
Уух ус хүрэлцээтэй				
Ослын гарц тодорхой тэмдэглэгдсэн				
Анхны тусламжийн болон галын хор бэлэн				
Утас, онцгой байдлын тусламжийн утасны дугаар, байр хариуцсан хүнтэй холбоо барих мэдээлэл бэлэн				
<b>ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ХЭРЭГСЭЛ</b>				
Тоног төхөөрөмж, хэрэгсэл нь тохиромжтой, нөхцөл сайн, оролцогчид элдэв гэмтэл учруулах эрсдэлгүй				
Ашиглаагүй тоног төхөөрөмж, хэрэгсэл нь оролцогчид саад болохооргүй хадгалагдсан				
Тоног төхөөрөмжийг норм, стандартын дагуу угсарсан				
Тоног төхөөрөмж цэвэрхэн, ариутгагдсан				
Тоног төхөөрөмжийг аюулгүй хэрэглэх зөвшөөрөл олгогдсон				
Оролцогчид тоног төхөөрөмжийг хэрэглэх заавар сайн авсан				
<b>ОРОЛЦОГЧИД</b>				
Оролцогчдын сэтгэл санаа, биеийн байдалд тааруулан үйл ажиллагааг төлөвлөсөн				
Оролцогчид эхэндээ биеэ хангалттай халаах бололцоотой				
Оролцогчид нь циркээр хичээллэхэд учирч болох оюул ослын талаар, бас биеэ аюулгүй авч явах тухай мэддэг				
Оролцогчдын сэтгэл санааны аюулгүй тайван байдлыг хангасан, дарамт сүрдүүлэг мэдрэхгүй орчныг бүрдүүлсэн				
<b>ДАСГАЛЖУУЛАГЧ, НИЙГМИЙН АЖИЛТАН</b>				
Оролцогчдын эрүүл мэндийн ерөнхий байдлыг мэддэг, үүнтэй холбоотой хувийн нууцыг нь хадгалж чалдаг				
Цусаар болон, бэлгийн замаар халддаг өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авах ёстойг мэддэг				
Онцгой байдал үүссэн үед мөрдөх журмыг авсан, тухайн үед гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа мэддэг				
Сургалтын багт нэгээс доошгүй хүн анхны тусламжийн сургалтанд суусан байна				





Оролцогчдын биеийн болон сэтгэл зүйн аюулгүй байдал нь нэн тэргүүний асуудал юм.

Аюулгүй байдал нь бүх хүний байнгын анхаарах зүйл.

Урьдчилан сэргийлэх болон мэдлэгтэй байх явдал нь аюулгүй байх гол баталгаа юм.

Мөрдөх шаардлагатай аюулгүйн хэм хэмжээ нь тухайн үеийн нөхцлөөсөө хамаараад өөрчлөгдөж байдаг тул нөхцөл байдал, хэм хэмжээгээ ойр ойрхон эргэн харах хэрэгтэй.

Аюулгүй байдлын асуудалтай тулгарахдаа өөрийн мэргэжлийн чадварыг хязгаарыг мөн мэддэг байх чухал.



# ЁС ЗҮЙ

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Ёс зүйн нийтлэг дүрэмтэй байхын ач холбогдолыг танин мэдсэн
2. Бүх арга хэмжээнд үнэт зүйлийн хүрээг баримтладаг
3. Ажил үүргийн хүрээ, хязгаараа ойлгож танин мэдсэн
4. Ёс зүйн дүрмийг тухайн нөхцөл байдалдаа тохируулан хүндлэн мөрддөг

*Монреалд бид панк төрхтэй нэгэн нийгмийн ажилтан бүсгүйтэй ажилладаг байлаа. Тэр эмэгтэй хүүхдүүдтэй гайхалтай сайхан харилцаатай байсан. Учир нь тэд гол төлөв ижил төрлийн дуу хөгжим сонсдог байсан юм. Нэг өдөр нийгмийн ажилтан маань над дээр нэг асуудалтай ирлээ. Монреалд панк хүмүүс бага, тэдний очдог газар ч цөөхөн байв. Баасан эсвэл Бямба гарагийн орой тэр баар эсвэл концертонд манай зарим хүүхэд залуучуудтай тааралддаг байлаа. Тэр ууж, бүжиглэж, зоргоороо байхыг хүссэн ч сургалтын үеэр ажиллаж байсан өсвөр насныхан нь мөн тэнд байжээ. Тэр над руу энэ нөхцөл байдалтай холбоотой үүсэж буй ёс зүйн асуудлын талаар ярилцахаар ирээд “Би Фуфун Электрикт байхдаа бага зэрэг хэтрүүлээд уучихвал харих хэрэгтэй болдог. Учир нь сургалтанд оролцогчдынхоо өмнө эвгүй байдалтай харагдахыг хүсэхгүй байна” гэж яриу. Эцэст нь тэр маш сайхан санаа гаргасан. Тэр үүссэн нөхцөл байдалаа ашиглаж тэдгээр хүүхэд, залуустай архи уух, хар тамхи хэрэглэх талаар илэн далаангүй яриа өрнүүлдэхээр болсон.*

Эммануэл Бошуд, Нийгэмшүүлэх циркийн Харилцааны ажилтан.  
Нийгэмшүүлэх цирк, Монреал





## НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ<sup>1</sup>

### ЗАН ТӨЛӨВИЙН ЗАРЧИМ, СТАНДАРТУУД

Аливаа ёс зүйн дүрмийн зорилго нь нийтлэг үндсэн зөвлөмжөөр хангах явдал юм. Энэхүү дүрэм нь нийгэмшүүлэх циркийн багш нарт зориулан сургалтын үед ямар зан байдал үзүүлэх, мөн ажиллаж буй соёлын нөхцөлдөө хэрхэн тохируулан биеэ зөв авч явах тухай зааварласан болно.

Нийгэмшүүлэх циркийн багш нар ихэнх тохиолдолд өмнө нь хууртаж мэхлэгдэж байсан, сэтгэлийн шарх авсан, эрсдэлд буй хүүхэд залуучуудтай ажилладаг. Эдгээр хүүхэд, өсвөр үеийнхэн гаргасан хүчин зүтгэлдээ асар их итгэл найдвар тавьж, багш нартайгаа итгэлд тулгуурласан харилцаа холбоо бий болгохыг хүсдэг.

Иймээс багш-оролцогч хүүхэд хоорондын харилцаа ердийн циркийн сургалтаас гүн утга агуулгатай байдаг. Энэ хүрээний бүхий л харилцаа оролцогчийн сэтгэлийг ойлгосон мэдрэмжтэй байдлыг шаарддаг. Мөн циркийн хөтөлбөр болон залуу оролцогчдод сөргөөр нөлөөлөх аливаа эвгүй нөхцөл байдал, хүчирхийлэл, үл хайхралаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой заавар зөвлөмжийг мөрдөхийг шаарддаг.

Дасгалжуулагч багшийг сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эсвэл олон нийтийн ажилтан байхыг шаарддаггүй. Гэхдээ тэд үүрэгт ажлаа хөтөлбөрт оролцож буй бүхий л хүүхэд өсвөр үе, журмын нөхөд, хамтран ажиллагчдаа гэсэн гүн хүндэтгэлд суурилан гүйцэтгэхтэй холбоотой тодорхой хариуцлагууд бий.

Дасгалжуулагч багш нар тэдний хандлага, зан байдал оролцогчидод үлгэр дууриал болно гэдгийг ойлгохын зэрэгцээ энэ нь хүүхдийг тодорхой ур чадварт сургахтай дүйцэхүйц чухал гэдгийг ухамсарлах ёстой.

Иймээс энэхүү бүлэгт нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш нарын циркийн сургалтын үед, түүнчлэн сургалтаас гадуур зарим үед мөрдөх ёстой зан хандлагын зарчим, үйлдлүүдийг тусгалаа.

Эдгээр зан төлөвийн стандарт, зарчмуудыг дасгалжуулагч багш нар хамгийн өндөр түвшинд биелүүлэхийг эрмэлзэх ёстой.

### ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

Нийгэмшүүлэх циркийн багш нарт зориулсан энэхүү ёс зүйн дүрэм нь нийгмийн болон боловсролын чиг хандлагатай спортын болон мэргэжлийн байгууллагуудын одоо мөрдөж буй дүрэм журамд суурилсан юм. Эдгээр нь нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багшийн тодорхойлолтод тохирсон, өөрөөр хэлбэл урлаг уран сайхан, нийгэм, спортын ёс зүйн хандлагыг нэг агуулгад багтаасан зүйл юм.

Уг дүрэм дараах түлхүүр зарчмуудад үндэслэсэн:

1. Чадвар дадал
2. Шударга байдал
3. Хувь хүний хариуцлага
4. Соёл уламжлалд хүндэтгэлтэй хандах
5. Нийгмийн хариуцлага

<sup>1</sup> Энэ нь Мишел Лафортуну боловсруулсан Нарны циркийн Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч нарын ёс зүйн дүрмийг дахин боловсруулсан хэсэг юм. Энэ нь дэлхий даяар 100 гаруй нийгэмшүүлэх циркийн сургалтад, мөн төв Cirque du Monde, Бразилийн Circo do Mundo-д ашиглагддаг болно. Ишлэлийг Мишел Лафортуну Нийгэмшүүлэх циркийн хөтөлбөрийн дасгалжуулагч, хамтрагчдад зориулсан гарын авлагын “Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчийн ёс зүйн дүрэм” хэсгээс авав. С.Дагенайс, С. Мерсиер, Ж. Ривард (Монтреал: Нарны цирк, Нийгмийн хэрэг, олон улсын харилцааны салбар, 2001), Баримтат хуудас 8.

6. Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал
7. Багийн ажиллагаа
8. Ажил олгогчтой тогтоох харилцаа

Эдгээр зарчим бүр дасгалжуулагч багш нарын үйл ажиллагаандаа баримтлах стандартуудын жагсаалт, тодорхойлолтой. Эдгээр стандартууд нь зарчим бүрийн чухал хэсэг болдог.

### **1. Чадвар дадал**

Дасгалжуулагч багш нь өөрийн эзэмшсэн, заах боломжтой арга техникийг тодорхой стандартын дагуу, аюулгүй байдалд заана. Дасгалжуулагч багш нь өөрийн чадварын хязгаарыг хүлээн зөвшөөрөх ба эдгээрийнхээ хүрээнд ажиллахын зэрэгцээ нийт чадвар чадавхиа хөгжүүлэн нэмэгдүүлэхийн төлөө байна.

- 1.1 Дасгалжуулагч багш нар нийгэмшүүлэх циркийн сургагч багшийн үндсэн сургалтыг дүүргэсэн байх ёстой.
- 1.2 Дасгалжуулагч багш нь өөрийн хийж буй үйлдэл ажиллаж буй хүүхэд залуучуудынх нь амьдралд ямар нэг нөлөө үзүүлнэ гэдгийг ухамсарлах ёстой.
- 1.3 Дасгалжуулагч багш нар үүргээ гүйцэтгэж байхдаа өөрсдийн мэдлэг, ур чадварын хүрээ, хязгаарыг анхаарч үзэх ёстой.
- 1.4 Дасгалжуулагч багш нар оролцогч нарын эрүүл мэндэд аюултай, эрсдэл ихтэй, шаардлага хангахгүй орчинд ажиллахаас түдгэлзэх ёстой.
- 1.5 Дасгалжуулагч багш нар оролцогчдын биеийн болон сэтгэл зүйн байдал, ур чадвар, туршлага, насанд тохирсон үйл ажиллагаа зохион байгуулах ёстой.
- 1.6 Дасгалжуулагч багш нар оролцогчдыг бага багаар системтэй сургах ёстой.
- 1.7 Дасгалжуулагч багш нар циркийн хичээлийг эерэг амьдралын туршлагад хөрвүүлэх ёстой.

### **2. Шударга байдал**

Дасгалжуулагч багш нар үйл ажиллагаан дахь оролцоо, сургалтаараа дамжуулан шударга байдлыг хадгалах үүрэгтэй. Тэд бусдад хүндлэл үзүүлж чин сэтгэлийн угаас ажиллах ёстой. Тэд өөрсдийн мэргэшил, туршлага эсвэл эрх мэдлийг худал мэдүүлэх ёсгүй. Мөн өөрсдийн хувийн сонирхлоо илэрхийлэх ёсгүй.

- 2.1 Дасгалжуулагч багш нар өөрсдийн итгэл үнэмшил, үнэ цэнэ, хүрээ хязгаарыг өөрийн ажил үүргэд нөлөөлөхийг ухамсарлах ёстой.
- 2.2 Дасгалжуулагч багш нар өөрсдийн үүргийг тодорхойлох ёстой, үүргийн дагуу ажиллаж байгаа хүмүүстэй харилцахдаа шаадлагыг мөрдөх ёстой.
- 2.3 Дасгалжуулагч багш нар хувь хүнийг түлхэж хөндийрүүлэхгүйгээр, зарим оролцогчдын зан араншинтай санал нийлэхгүй байж болно гэдгийг ойлгох ёстой.
- 2.4 Дасгалжуулагч багш нар сургалтын үеэр өөрийн үүргээ гүйцэтгэж цалин авахаас өөр аливаа сэтгэл хөдлөлийн, эдийн засгийн, бэлгийн давуу талаар санал болгоход хүлээн авахаас түдгэлзэх ёстой.
- 2.5 Дасгалжуулагч багш нар оролцогч нартай ойр дотны бэлгийн харилцаа үүсгэж болохгүй.
- 2.6 Дасгалжуулагч багш нар бүх бэлгийн болон сэтгэлд зүйн санаа зовоосон үйлдлүүдээс түдгэлзэх ёстой.
- 2.7 Дасгалжуулагч багш нар аливаа буруу үйл ажиллагааг үйлдэх ёсгүй.
- 2.8 Дасгалжуулагч багш нар өөрийн ажилд хамааралгүй хүний оюуны, сэтгэл зүйн, эсвэл эд хөрөнгийн байдлаар туслуулаад заавал мэдэгдэх ёстой.

### **3. Хувь хүний хариуцлага**

Дасгалжуулагч багш нар өөрсдийн үйл хэрэгтээ хүлээх хариуцлагыг хүлээн зөвшөөрч, ажиллаж байгаа хүмүүсийнхээ хэрэгцээт арга барилыг тохируулан ажиллахыг эрмэлзэнэ.

3.1. Дасгалжуулагч багш нар ёс зүйн дүрэмтэй зөрчилдөж байгаа аливаа зан хандлага, оролцогчдод тулгарч буй аливаа аюулаас зайлсхийхийн тулд бусад багийн ажилтнуудтайгаа зөвшилцөх ёстой.

3.2. Дасгалжуулагч нь тодорхой хуваарь, зорилт, боломжит эх сурвалжийн дагуу үүргээ биелүүлэхийн тулд хүчин чармайлт гаргахыг хүнэтгэх ёстой.

3.3. Дасгалжуулагч багшийн бэлтгэл сургуулилалт, хэрэгжиж буй сургалтанд сэтгэл дундуур байсан ч, дасгалжуулагч багш нар хувийн нууцыг хатуу чанд хадгалах ёстой.

#### **4. Соёл уламжлалд хүндэтгэлтэй хандах**

Дасгалжуулагч багш нар бүх хувь хүмүүсийн соёл, сайн зан чанар, тулгуур эрхэд хүндэтгэлтэй хандана. Энэ нь хувийн мэдээлэл, нууц хадгалах байдал, тусгаар байдал болон хувь хүний эрх мэдэлд хүндлэлтэй хандана гэсэн үг юм.

4.1. Дасгалжуулагч багш нар хувийн болон бусдын эрх ашгийн төлөө сургалтанд оролцогчдын хувийн нууцыг тэдэнд хортой байдлаар ашиглаж болохгүй.

4.2. Дасгалжуулагч багш нар суралцагч нарын хувийн амьдралтай хамааралтай асуудлаар хандахдаа ухаантай, зөв бодолтой, нууцыг хүндэлсэн байх ёстой.

4.3. Судалгааны төсөлд оролцвол төсөлд хамрагдаж байгаа оролцогч өөрөө хүсэж, мэдэж оролцох, татгалзсан тохиолдолд аливаа цээрлэл, шийтгэл эдлэнэ гэж итгэхэд хүргэхгүй байхад анхаарна.

#### **5. Нийгмийн хариуцлага**

Нийгэмшүүлэх сургалтыг зохион байгуулж байгаа олон нийтийн бүлгийн өмнө дасгалжуулагч багш хариуцлагатай, нээлттэй байна.

5.1. Дасгалжуулагч багш нь хувь хүмүүс болон олон нийтийн бүлгүүдэд өөрсдийн тусгаар, бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд нь туслах үйл ажиллагаануудыг төлөвлөсөн байх ёстой. Хүчээр хянан эрхшээлдээ байлгах, хэт давамгайлах зорилготой үйлдлүүд гарч болохгүй.

5.2. Дасгалжуулагч багш хүн бүрийн хувьд нийгмийн шударга ёс, хүлээн зөвшөөрөл, хараат бус бие даасан байдал, хүндэтгэл үзүүлэх ёсыг баримтлах ёстой. Мөн тэд суралцагсдад тухайн орон нутаг, олон нийтийн хүрээнд харилцан туслалцаж дэмжих хүрээлэлтэй болоход нь туслах чухал.

5.3. Дасгалжуулагч багшид нь өөр бусад дасгалжуулагч ёс зүйн зарчмуудтай үл нийцэх байдлаар суралцагчдад нөлөөлөх гэж оролцвол хөндлөнгөөс оролцох нь зүйтэй.

5.4. Дасгалжуулагч багш нар ямарч нөхцөл байдалд өөрсдийн байр суурийг үзэл суртлын зорилгоор эсвэл өөрсдийн болон өөр хэн нэгний төлөө шударга бус, хууль бус ашиг олж авахыг оролдох, олж авахаар ашиглах ёсгүй.

#### **6. Бие махбодын болон сэтгэл санааны аюулгүй байдал**

Дасгалжуулагч багш нар сургалт байрлаж буй газар дахь орчны аюулгүй байдалд хариуцлага хүлээдэг. Тэд сургалтын тоног төхөөрөмжүүд найдвартай, бүрэн хэрэглэгдэх боломжтой байдлыг хангана. Суралцагсдыг эрсдэлтэй хөдөлгөөн хийхэд туслахдаа сэрэмжтэй байх ёстой. Эсвэл ийм арга техникийг оролдож үзэж байгаа хүний аюулгүй байдлыг хангаж чадах хүний хараа хяналт дор хийх ёстой.

Дасгалжуулагч багш нар харилцан хүндлэл бүхий сэтгэл зүйн аюулгүй орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Тэд суралцагсдад итгэлцэл төрүүлж, бүлэг дотроо өөрсдийн гэсэн байр сууриа эзлэхийг баталгаажуулах ёстой.

6.1. Дасгалжуулагч багш оролцогчдыг аюулгүй нөхцөлд үйл ажиллагаанд оролцуулах ёстой.

6.2. Дасгалжуулагч багш оролцогчдод өөрсдийгөө болон бусдыг хамгаалах арга хэмжээний талаар мэдүүлж аюулгүй байдлаа хангах хариуцлагаа хүлээх тухай заах ёстой.

6.3. Дасгалжуулагч багш нар оролцогчдыг хөгжиж зугаацахыг дэмжиж, шударга байдал, хамтын ажиллагааг хангасан эерэг орчинд сэтгэл хангалуун суралцахад дэмжих ёстой.

6.4. Дасгалжуулагч багш оролцогчдыг зохих түвшинд сахилга бат, дэглэмтэй байхыг сургахын зэрэгцээ янз бүрийн орчин нөхцөлд уян хатан хандаж, тохируулж ажиллахыг чухалчилна.









Ёс зүйн дүрэм бол тухайн улс орон эсвэл оролцогч нараас үл хамааран хамтын ажиллагааг хялбаршуулж өгдөг зөвлөмжийн хүрээ юм. Энэ бол нийтлэг тодорхойлогдох заавар, зан үйлийн дүрэм, нэгдсэн удирдамж юм.

Ёс зүйн дүрэм нь үйл ажиллагаа бүрийг тогтвортой, жигд болгодог.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан, оролцогчид, болон хамтрагч байгууллагуудын гишүүн хоорондын ялгаа нь зөрчилдөөнд хүргэж болно. Ёс зүйн дүрмийг боловсруулах нь зарим болзошгүй зөрчилдөөнийг эхлэхээс нь ч өмнө намжаадаг.



# Сургалтын арга барил

## Зорилт

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Нийгэмшүүлэх циркийн сурган заах аргад нөлөөлдөг арга барилуудыг таньж мэддэг.
2. Нийгэмшүүлэх циркийн зарчим болон заах арга барил хоорондын холбоосыг ойлгодог.
3. Сайн сурган хүмүүжүүлэгчийн давуу тал ба саад бэрхшээлийг тодорхойлж чаддаг.
4. Суралцахад таатай аюулгүй орчныг бүрдүүлдэг нөхцөл байдлыг сайн мэддэг.

*Сургалтын арга барилын нэг хэсэг нь зочломтгой, найрсаг, сэтгэлийн тавгүй байдал, заналхийлэлгүй, ямар нэгэн болзолгүй, хүүхэд өсвөр үе хэзээ бэлэн болсон тэр үед нь оролцохыг зөвшөөрдөг орчныг бүтээхээс бүрддэг. Би Лос анжелос дахь манай циркийн сургалтанд 2 жил ирсэн хэрнээ ямарч үйл ажиллагаанд оролцож байгаагүй нэг хүүг санаж байна. Тэр учир нь олодохгүй гэжүүд зантай, эргэн тойрон харах дуртай ч хэзээ ч оролцож байгаагүй. Эцэстээ тэр оролцохоор шийдэхэдээ маш хурдан сурч гайхалтай жонглёрч болсон. Өнөөдөр тэр манай хамгийн өндөр түвшний хичээнгүй үнэнч оролцогч нарын нэг. Тэрээр 5 цахиур 7 бөмбөгөөр жонглёрдож чаддаг. Хэрвээ бид түүнийг оролцуулахаар хэтэрхий ятгаж, эсвэл шахаж шаардсан бол магадгүй зугтах байсан биз. Гэхдээ бид уужуу тайван байсан учраас, ямар нэгэн нөхцөл тавилгүйгээр түүнийг ажиглаж нээлттэй байснаар, тэр бэлэн болсон үедээ өөрийнхөө зөнгөөр бидэнтэй ойртох боломжтой болсон юм. Энэ л бид түүнд хурч нөлөөлж чадсан арга барил юм.*



Филипп Соломон, Нийгэмшүүлэх циркийн  
дасгалжуулагч багш  
Нийгэмшүүлэх цирк, Лос Анжелес





## **ХОЛБОГДОХ СУРГАЛТЫН АРГА БАРИЛУУД**

Орчин үеийн ижил сургалтын арга барилууд Нийгэмшүүлэх циркийн хэв маягтай төстэй байдаг. Эдгээр олон арга барилууд дундаас бидний хувьд хамгийн сонирхолтой нь туршилтаар суралцах, бодит нөхцөл тулгуурлан суралцах, хамтран ажиллаж суралцах, стратеги бодлоготой сургууль болон шүүмжлэлт сэтгэлгээтэй суралцах зэрэг юм.

### **1. Туршилтаар суралцах**

Туршилтаар суралцах арга нь хүнөөрөөшууд туршиж үзэн уримтлуулсны дараа, эргэцүүлсэн үйл явц нь үйлдэлд хөтөлдөг.

### **2. Бодит нөхцөлд тулгуурлан суралцах**

Мэдлэгийг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлдэг учраас салгаж ойлгох боломжгүй. Хувь хүн ямар нэгэн бодит, утга учрыг суралцамагц тэр мэдлэгийг эзэмших түвшинд хүрдэг. Эдгээр ойлголтонд тулгуурлан, өөрийн эзэмшсэн мэдлэгээ бодит байдалд хөрвүүлэхэд нь туслахын тулд оролцогчдыг бодит орчинд оруулан тухайн нөхцөлд тулгуурлан сургадаг.

### **3. Хамтран ажиллаж суралцах**

Хамтран ажиллаж суралцах нь олж авсан мэдлэгээ харилцан солилцоход ач холбогдол өгдөг. Энэ арга барил нь харилцан дэмжих зарчимд тулгуурладаг: бүх оролцогч нар бусаддаа туслах, мөн олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах ёстой. Учир нь нэгдмэл даалгавар нь багаар хамтран гүйцэтгэж суралцах үйл явцаа сайжруулахад оршино. Үүсч байгаа бэрхшээлээс санаа авч багаараа хэлэлцэж, түүндээ шүүмжлэлтэй хандан, идэвхитэй оролцоотой байх нь сурсан зүйлсийг илүү үр дүнтэй холбож өгдөг.

### **4. Стратегитай суралцах**

Стратегитай суралцах арга барил нь сурах үйл явцад оюуны хөгжлийг голчлон анхаардаг. Багш нь юуны өмнө оролцогчийн өмнөх мэдлэгийн түвшинг мэдсэн байх шаардлагатай бөгөөд шинээр ямар мэдлэг олгох хэрэгтэйг тооцоолох ёстой. Мөн багш нь суралцагчдыг мэдлэгээ үр дүнтэй хэрэглэж байгааг батлахын тулд тэдний ой санамжийг сайн ашиглана. Сэтгэлзүйн хүчин зүйл нь суралцах арга барилд их нөлөөлдөг: багш сурагч хоорондын хувийн харилцаагүйгээр энэ аргаар суралцах боломжгүй юм. Сайн багш бол оролцогчийн амьдралын гайхалтай сонирхолтой чанарууд, соёлын нөхцөлд байдалд хамтын ажиллагаа бий болгох замаар багшлах нь ямар утга учиртайг ойлгуулж чаддаг.

### **5. Шүүмжлэлт сэтгэлгээ**

Шүүмжлэлт сэтгэлгээ нь шийдвэр гаргах чадвар, нийгмийн хариуцлагыг идэвхижүүлэх сургалтын арга юм. Энэ арга нь асуудлыг олон талаас нь харж, харилцан дэмжсэн эрх тэгш харилцааг бий болгодог. Суралцах үйл явц нь бодит байдалд тулгуурласан, бодит амьдралын туршлагатай холбогдсон, өдөр тутмын түгээмэл ойлголтонд үндэслэсэн байна гэдгийг энэ аргаар сайшаадаггүй. Мөн чанартаа, боловсролын сургалтын орон зай нь хязгаарлагдахгүй бөгөөд нийгмийн үйл хэрэг чиглүүлэх ёстой.









Нийгэмшүүлэх циркийн сургалтын арга барил нь бүгдийг тэгш хамруулдаг.

Нийгэмшүүлэх циркийн нэн тэргүүний зорилго нь хувь хүний болон нийгмийн хөгжил юм.

Үйл явц үр дүнгээс илүү чухал.

Сурч байгаа болон сургаж байгаа хүмүүсийн хооронд сэтгэл зүйн харилцаа бий болоогүй суралцах боломжгүй.

Нарны цирк нь дасгалжуулагч багш болон олон нийтийн ажилтны хамтарсан сургалтын арга барилыг дэмждэг.



# СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Нийгэмшүүлэх циркийн сургалтын төлөвлөлтийн үйл явцыг ойлгох.
2. Сургалтыг төлөвлөхдөө юуг анхаарах ёстойг тодорхойлох.
3. Арга техникийн болон нийгмийн зорилгыг хэрхэн нийцүүлэхийг ойлгох.
4. Сургалтыг төлөвлөхдөө дасгалжуулагч багш, олон нийтийн ажилтны хамтран ажиллагааны давуу талыг олж мэдэх.

*Сургалтыг төлөвлөлтөнд нийгмийн ажилтнууд юу хэлэхийг сонсох нь төвөгтэй байдаг. Учир нь тэд өдөр бүр хүүхэд, өсвөр үеийнхэнтэй хамтарч ажилладаг. Ерөнхийдөө, дасгалжуулагч багш бид, долоо хоногт сургалтын хэдхэн цаг тэдэнтэй хамт байдаг. Тиймээс энэ богино хугацаанд хүүхдүүд юу сонирхдогийг ойлгох нь боломжгүй юм. Лос Анжелос дахь Гей болон Лесбиан нарын төв дээр төлөвлөгөөгөө гаргах гэж олон долоо хоног болсон ч гол зүйлсээ тодорхойлж чадахгүй байлаа. Бухимдаж төөрөлдсөн би хүний нөөцийн ажилтанруу очиж хэрхэн зохицуулахыг асуулаа. Тэр надад энэ төвийнхөн нүүр будах, жижиглэх дуртай болохоор нүүрний будгаас эхлэ гэж зөвлөсөн юм. Дараах долоо хоногт нь, бид будалт хийх сургалт зохион байгуулсан юм. Сургалт амжилттай явагдснаас гадна олон саад бэрхшээлийг даван туулахад тусласан юм. Энэ нь олон оролцогчидод гүн сэтгэгдэл төрүүлж, сургалтын уур амьсгалыг сайхан болгосон билээ.*



Филипп Соломон, Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч багш, Нийгэмшүүлэх цирк, Лос Анжелос



Энэ хүснэгт нь 15 сургалтын загвар төлөвлөгөө бөгөөд долоо хоногт 2-3 цагаар хуваагддаг. Өөрийн орны нөхцөл байдалд тохируулан тус хүснэгтэд өөрчлөлт оруулаарай.

### Нийгэмшүүлэх циркийн сургалтын төлөвлөгөө

Сургалтын ерөнхий зорилт: Жишээ нь: Нэгдмэл бүлэг байгуулах. – Оролцогчид болон олон нийтийн хоорондын харилцааг сайжруулах – Хөвгүүд охид хоорондын харилцааг сайжруулах – Оролцогчдын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх – Оролцогчдод өөрийн биеийг хянаж сурахад дэмжих –БЗХӨ-өөс сэргийлэх– Оролцогчдын согтууруулах ундаа, хар тамхины хэрэглээг багасгахад туслах.

7 хоног	Мэргэжлийн түвшин зорилтууд Циркийн хичээл	Нийгмийн зорилтууд Амьдралын сургаж
1	БҮЛЭГ 1 – Циркийн арга техникийг танилцуулах 4 долоо хоног	БҮЛЭГ 1 – Баг бүрдүүлэх 4 долоо хоног
2	<i>Циркийн арга техник нь бүлэг бий болгох зорилготой холбогдож байгаа талаар танилцуулах</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчдыг танилцуулж, харилцан бие биенээ дэмжсэн шинэ харилцааг холбоог хөхиүлэн дэмж.</li> <li>• Багийн нэгдэл, хэрэгцээг үнэлэх. /ЖШ: манлайлагч, загвар үзүүлэгч, /</li> <li>• Зан төлвийн дүрэм бий болго.</li> </ul>
3	<ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчийн бие бялдрын чадварыг үнэлэх.</li> <li>• Бага багаар биеийн хүчний даалгаварыг нэмэгдүүлэх, ингэхдээ биед хүрэхдээ мэдрэмжтэй бай. .</li> </ul>	
4		
5	БҮЛЭГ 2 – Чадвар шаардсан техникуудад суралцах 6 долоо хоног	
6	Оролцогчдод циркийн арга техникийн дохио командыг зааж багийн хамтын ажиллагааг дэмжих.	Багтайгаа хамт байх, хамтран гүйцэтгэх дасгалуудыг үргэлжлүүлэн хий.
7	<ul style="list-style-type: none"> <li>• Бүх арга техникийг нарийн сурга.</li> <li>• Илүү итгэлцэл шаардагдах арга техникийг эрчимжүүл.(ж.нь. гар гар дээрээ зогсож пирамид бий болгох гэх мэт).</li> <li>• Бүтээлч дасгал, тайзны урлагийг онцло.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Албан болон албан бус уулзалтыг дэмж</li> <li>• Хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих дасгалуудыг нэмэгдүүл. Жнь: Өөрөө итгэл итгэлцэл бий болгох г.м</li> <li>• Оролцогчдын дунд бие махбодийн хувьд ая тухтай байдал бий болгоход туслах.</li> <li>• Сургалт болон нийгмийн дэмжлэг үзүүлэхэд багийн нөөцийг ашигла.</li> </ul>
8		
9		
10		
11	БҮЛЭГ 3 – Циркийн нэг арга техникт төвлөрөх 3 долоо хоног	БҮЛЭГ 3 – Багийн хөгжлийг эрчимжүүл 3 долоо хоног
12	<ul style="list-style-type: none"> <li>• Үзүүлбэрийн тоог гарга.</li> <li>• Давтан шалгаж, дарааллын дагуу бэлд.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Багийн төсөлд хувь нэмэр оруулах чадварыг хөгжүүл. Тоглолтын үеэр шийдвэр гаргах стресс менежменттэй байхад суралцуул..</li> </ul>
13		
14	<b>БҮЛЭГ 4 – ЭЦСИЙН ШАТНЫ БЭЛТГЭЛ БА ТОГЛОЛТ</b>	
15	БҮЛЭГ 5 – СУРСАН ЗҮЙЛДЭЭ ДҮГНЭЛТ ХИЙХ 1 тоглолт	БҮЛЭГ 5 – БАГИЙН ТУРШЛАГЫГ ДҮГНЭХ 1 үзүүлбэр
	<ul style="list-style-type: none"> <li>• Тоглолтонд үнэлгээ өгөх.(ж.нь.видео бичлэг хийж үзэх).</li> <li>• Суралцсан арга техникийг үнэлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Багийн болон хувь хүний хөгжилд дүгнэлт өг.</li> <li>• Дараагийн хөтөлбөртөө болон бусад нөөц боломжийн талаар мэдээлэл хүргэ.</li> </ul>

Та 51 дүгээр хуудсанд хоосон хүснэгтийг олж болно.

### Нийгэмшүүлэх циркийн хичээлийн төлөвлөгөө

СУРГАЛТ: #2	Үргэлжлэх хугацаа: 3 цаг	Оролцогч: 7 охин 14 хөвгүүд
ДАСГАЛЖУУЛАГЧ БАГШ: МАМАОДОУ, ЖЕНЕВИЕВЕ	Олон нийтийн ажилтан:Алисе	БУСАД: тодорхойгүй

Сургалтын ерөнхий зорилт:  
Оролцогчдын талаар олон нийтийн ойлголт болон олон нийтийг талаарх оролцогчийн ойлголтыг өөрчлөх

Циркийн сургалтын зорилго Циркийн хичээл	Нийгмийн сургалтын зорилго Амьдаралын хичээл
<ul style="list-style-type: none"> <li>- Бие халаах дасгалуудыг хийж занш.</li> <li>- Циркийн зарим үзүүлбэрүүдийг судал:пирамид бий болгох, гар гараас барих, жонглёрдох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ харилцаа холбоог дэмжиж, хобоос үүсгэ. (баг болон итгэлцэл бий болгох үзүүлбэр).</li> <li>- Багийг сэдэлжүүлж, хөгжилтэй бай, амжилт ол.</li> </ul>

### Хуваарь

Ойролцоогоор үргэлжлэх хугацаа	ҮЙЛ АЖИЛЛАГАА (Мэндчилгээ, завсарлага, хаалт зэрэг бүх үйл ажиллагааг багтаах.)	Чиглүүлэгч	Ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зүйлс (материал, аюулгүй байдал, бие халалт, баг бүрдүүлэлт, сэдвийн хэлэлцүүлэг гэх мэт)	Гүйцэтгэл	
				Тийм	Үгүй
10 мин.	Оролцогчтой мэндчилэх	Бүгд	Сэтгэлзүйн бэлтгэлтэй бай.	x	
5 мин.	Сургалтыг танилцуулах	Алисе		x	
15 мин.	Нэр тогтоох тоглоом: Өндөрт харайх (Магтахдаа нэрээр нь дуудах)	Мамоудуу	Шохой	x	
15 мин.	Тоглоом: Гурвалсан өргөлт	Женевиеве	3 бөмбөг, 3 баг	x	
15 мин.	Бие халаалт	Мамоудуу, Женевиеве	Гимнастикийн залны гудас	x	
20 мин.	Баг бүрдүүлэх: олсон доогуур!	Алисе	3 баг, гудас, дээс	x	
10 мин.	Завсарлага	Бүгд	Ундаа, хөнгөн зууш, оролцогчдод туслах, яриа өрнүүлэх	x	
45 мин.	Хоёр хувилбарт ажил:Жонглёр, гараас гарт	Мамоудуу (жонглёр) Женевиеве (гараас гарт)	2 баг, бөмбөг, гудас Мамоудуу цаг барих болон бүлэг сойлгдохыг хариуцах.	x	
25 мин.	Пирамид байгуулах	Женевиеве	Матрас, дэвтэр, пирамидын зураг		x
5 мин.	Тоног төхөөрөмжөө хураах	Бүгд		x	
10 мин.	Дүгнэлт: яриа өрнүүлэх	Алисе	1 жонглёрын клуб	x	
5 мин.	Хаалт, Дээсэн тойрог	Мамоудуу	1 баг бөх дээс, үзүүрийг сайн холбосон байх		x

### Дараагийн шат

Нийтлэгсэтгэгдлүүд:

- (бүлгийн хөгжил, тулгарсан сорилтууд, нийтийн нөлөөлөх ажил, сайжруулах ажил гэх мэт)
- Сайн баг бүрдсэн. Багаар ажиллахад найз болон хамтрагч нарыг салгахыг анхаарах
  - Гараас гарт дасгал нь зарим тохиолдолд төвөгтэй байна. Илүү тохиромжтой тоглоомыг ол.
  - Дараагийн сургалтанд пирамид байгуулахад илүү цаг гарга.
  - Зарим оролцогчид бусдын талаар сөрөг санал дэвшүүлвэл анхаарахгүй байх..
  - Завсарлагааны үеэр орхиж явсан Валентиног шалгах
  - Жонатан. Ребека нар баг дотроо бүрэг байна.

Дараагийн сургалтын зорилтууд

- Гараас гарт, болон жонглёрыг үргэлжлүүлэх. Пирамид, рола болаг танилцуулах.
- Оролцогчидыг хоорондын холбоог дэмжих. Жонатон, Эрэбэка хоёрыг оролцуулахад анхаарах

Та 53 дүгээр хуудсанд хоосон хүснэгтийг олж болно.







Циркийн арга техник сургах зорилго нь нийгэмшүүлэх зорилготой нийцсэн байна.

Оролцогчийн бие махбодийн болон сэтгэл зүйн нөхцлийг үнэлэх нь хувь хүний хэрэгцээнд тохирсон төлөвлөлтийг бий болгоход тусладаг.

Дэвшингүй аргаар сургалт явуулах нь сурах үйл явцын чухал агуулга юм.

Сургалтыг төлөвлөх нь үйл ажиллагааны дараалал, нөлөөлөх цаг мөч, шаардлагатай материалыг тодорхойлдог учраас сургалтын дэглэмийг баталгаажуулж өгдөг.

Төлөвлөлт нь оролцогч болон багш нарын стрессийг бууруулж, сахилга батыг хатуу барих нөхцөлийг бууруулдаг.



# БҮТЭЭЛЧ ЧАДВАР

## ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд нийгмийн ажилтан, дасгалжуулагч багш нар дараах чадвартай болсон байна:

1. Нийгэмшүүлэх циркид бүтээлч чадварын ач холбогдол, үүргийг талаар судлах
2. Нийгэмшүүлэх циркийн нөхцөлд төрөл бүрийн бүтээлч үйл явцыг хэрэглэх.
3. Хүүхэд, өсвөр үеийн оролцогчдын чадварт нийцсэн бүтээлч ажиллагааг тохируулах
4. Нийгэмшүүлэх циркийн загвар тоглолттой холбоотой асуудал болон ашиг тусыг ойлгох

Энэ жилийн тоглолтын сэдэв нь “Аврага биетүүд” байлаа. Баие-Сэинт-Паулд Нийгэмшүүлэх циркийн жүжигчид оролцсонбаярын жагсаал болсон. Манаванд, бид аврага хүмүүстээ зориулан уламжлалт уургуул иргэдийн багт наадмыг зохион багйуулсан. Энэ нь сэдвээ үндэсний уламжлалтай холбосон арга байлаа. Эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээр хамт ажиллаж байгааг харахад үнэхээр сайхан байсан. Ийнхүү уламжлалтай холбох нь хүүхэд, өсвөр үеийнхэнд урам дэм болж байсан юм. Үүгээр тэд өөрсдийгөө тодорхойлж байв. Хүүхдүүд Саманчууд болон уламжлалт хөгжмийг сонирхон сонсож, хип хопдуулж байсан.

Алисе Экакан,  
Манаван дахь нийгэмшүүлэх циркийн  
тусгай боловсролын мэргэжилтэн











Бүтээлч сэтгэлгээ хүмүүст шинэ ертөнцийг бүтээж, шинэ сайхан боломжуудыг нээх бололцоо олгодог.

Өөрийгөө байж болох бүхий л төрлөөр илэрхийлэх явдлыг дэмжих нь бүтээлч орчныг бий болгодог.

Дасгалжуулагч багш, нийгмийн ажилтан нь бүтээлч арга барилыг ашиглаж оролцогчид хоорондын харилцааг өдөөдөг

Тоглолт хийх нь өөрөө эцсийн зорилго биш харин нэг төрлийн төгсөлтийн ёслол юм. Энэ нь оролцогчид тодорхой сорилыг давж, хүлээлтэд нийцсэн эсвэл бүр давсан үзүүлбэр хийх боломжийг олгодог.



# ХАВСРАЛТ





СУРГАЛТЫН ЕРӨНХИЙ ЗОРИЛТ:

ДОЛОО ХОНОГ	ТЕХНИКИЙН ТАЛЫН ЗОРИЛТ Циркийн сургамж	НИЙГМИЙН ТАЛЫН ЗОРИЛТ Амьдралын сургамж
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		
11		
12		
13		
14		
15		









## ТОГЛООМЫН САНАЛ

ТОГЛООМЫН НЭР:

ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

ОРОЛЦОГЧДЫН ТОО:

ГОЛ ЗОРИЛГ:

(ЖИШЭЭ НЬ: : БИЕ ХАЛААХ, БАГААР АЖИЛЛАХ, ЭВСЭЛ САЙЖРУУЛАХ, АНХААРАЛ ТӨВЛӨРӨЛ, СЭРГЭЭХ, ХИЧЭЭЛИЙГ НЭЭХ, ХААХ ГЭХ МЭТ)

МАТЕРИАЛ:

ДАРААЛАЛ:

СЭТГЭГДЭЛ, САЙЖРУУЛАХ САНАЛ:

ТОГЛООМ САНААЧИЛСАН ОРОЛЦОГЧИЙН НЭР:





## ТОГЛООМЫН САНАЛ

ТОГЛООМЫН НЭР:

ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

ОРОЛЦОГЧДЫН ТОО:

ГОЛ ЗОРИЛГ:

(ЖИШЭЭ НЬ: БИЕ ХАЛААХ, БАГААР АЖИЛЛАХ, ЭВСЭЛ САЙЖРУУЛАХ, АНХААРАЛ ТӨВЛӨРӨЛ, СЭРГЭЭХ, ХИЧЭЭЛИЙГ НЭЭХ, ХААХ ГЭХ МЭТ)

МАТЕРИАЛ:

ДАРААЛАЛ:

СЭТГЭГДЭЛ, САЙЖРУУЛАХ САНАЛ:

ТОГЛООМ САНААЧИЛСАН ОРОЛЦОГЧИЙН НЭР:









